



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/114

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нэвт рашаан амралтын газар зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, урсгал засвар өргөтгөл хийх ажлыг гүйцэтгэгч "Ховд ганган нуур" ХХК, "БГМ" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч Ц.Ганданповрон -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Н.Ганбат - "Мянган Угалзат" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газрын дарга

Н.Цолмон - Орон нутгийн өмчийн газрын өмчийн харилцааны мэргэжилтэн

Л.Батгэрэл -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Д.Бямбасүрэн - Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2.Нэвт рашаан амралтын газар зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, урсгал засвар өргөтгөл хийх ажлыг гүйцэтгэгч "Ховд ганган нуур" ХХК, "БГМ" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Zax A/114 Ch
02 00505